



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Албан байгууллага /оффис/-ын үйлчлэгчийн
цэвэрлэх талбайн жишиг норм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан байгууллага /оффис/-ын нэг үйлчлэгчид ногдох цэвэрлэх талбайн жишиг нормыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү жишиг нормыг үндэслэн өөрийн байгууллагын онцлогт тохируулан үйлчлэгчийн цэвэрлэх талбайн хэмжээг тогтоох, хөдөлмөрийн норм, нормативаа боловсруулж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөсүгэй.

САЙД



Х.БУЛГАНТУЯА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
А/54 дугаар тушаалын хавсралт



Албан байгууллага /оффис/-ын нэг үйлчлэгчид ногдох
цэвэрлэх талбайн жишиг норм

Энэхүү жишиг нормыг дулааны улиралд хийсэн хэмжилтэд үндэслэн тооцсон тул
өвлийн улиралд нэмэгддэг ачааллыг харгалзан цэвэрлэх талбайн хэмжээг тогтооход
анхаарна уу.

А/ Оффисын өрөө

Талбайн ялгавар	Хана болон шалны хэмжээ, м ²		
	Мод	Паркет	Плита
Нэг үйлчлэгчид ногдох талбайн хэмжээ	250-300	300-350	275-325

Тайлбар: Нийт цэвэрлэх талбайн хэмжээнд цонх болон бусад цэвэрлэж буй эд
хогшлын тоог оруулан тооцно.
Нийт цэвэрлэх талбайн хэмжээ=Нэг үйлчлэгчид ногдох талбайн хэмжээ /м²/+бусад
цэвэрлэж буй эд хогшлын тоо+цонхны тоо

Б/ Ариун цэврийн өрөө

Талбайн ялгавар	Хана болон шалны хэмжээ м ²	Суултуур	Бясаагуур	Угаалтуур
Нэг үйлчлэгчид ногдох талбайн хэмжээ	150	12	7	10

Тайлбар: Нийлбэрээрээ 150 м²-аас дээшгүй талбайд суултуур, бясаагуур,
угаалтуур, /почки, унитаэ/ хана зэргийг оролцуулан тооцно. Нэг өрөөний цэвэрлэх
дундаж хугацаа 25 минут байна.

В/ Оффисын өрөө, ариун цэврийн өрөө хамтад нь бол

№	Талбайн ялгавар	Өрөөний тоо	Нэг өрөөний цэвэрлэх дундаж хугацаа /минут/	Нэг өрөөний дундаж м ²	Хана болон шалны дундаж м ²	Суултуур	Бясаагуур	Угаалтуур
1	Оффисын өрөө /бусад талбай, коридорыг оруулсан/	9	30	26.1	200-250	-	-	-
2	Ариун цэврийн өрөө	3	19	6.5	19.5	5	2	3
3	Бусад талбай	-	20.7	-	56	-	-	-

Тайлбар: Өрөөний нийт цэвэрлэх талбайн хэмжээнд цонх болон бусад цэвэрлэж буй эд хогшлын тоог оруулан тооцно. Бусад талбайд коридор, шат болон гадна талбайг оруулна.